

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, ГАДААД ХАРИЛЦААНЫ
САЙД, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА, МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА,
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА, МОНГОЛ
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРЫН ХАМТАРСАН ТУШААЛ,
ЗАХИРАМЖ**

**2017 оны 1 дугаар
сарын 16-ны өдөр**

**Улаанбаатар
Дугаар 17/10/10/38/02/03/10/01 хот**

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ




Хууль тогтоомжийн тухай хуулийн 45 дугаар зүйл, Захиргааны ерөнхий хуулийн 72 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.7 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 10 дугаар зүйл, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 31 дүгээр зүйлийг тус тус үндэслэн эрх зүйн мэдээллийг олон нийтэд нээлттэй, шуурхай хүргэх, эрх зүйн хэм хэмжээний уялдаа холбоог сайжруулах зорилгоор ТУШААН ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийг ажиллуулах журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн санд байршуулах мэдээллийн төрөл, хугацаа, хариуцах байгууллага”-ыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд мэдээлэл оруулах, хянах чиг үүргийг хариуцах ажилтны ажлын байрны тодорхойлолтод тусгах, үр дүнгийн гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлт болгох, энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга /Б.Даажамба/, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Баясгалан/, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга /Д.Даваасүрэн/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын нарийн бичгийн дарга /Д.Амгалан/, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга /Б.Нэргүй/, Монгол Улсын Үндсэн Хуулийн Цэцийн Тамгын газрын Хууль зүйн үйлчилгээний газрын дарга /Н.Болортунгалаг/, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга /Д.Отгонбаатар/ нарт даалгасугай.

3. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн хэвийн үйл ажиллагааг хангахад шаардагдах зардлыг жил бүрийн төсөвтөө тусгаж байхыг холбогдох байгууллагын төсвийн шууд захирагчид даалгасугай.

4. Энэ тушаал, захирамж батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Монгол Улсын Дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга нарын хамтран баталсан 2007 оны 22,40,3Г-3/06,234,50,341 тоот захирамж, тушаалтыг хүчингүй болсонд тооцсугай.



Монгол Улсын Засгийназрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд, Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Үндсэн хуулийн цээцийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга нарын хамтарсан 2017-жилийн 17/11/04/36/02/са/14/дугаар тушаал, захирамжийн 1 дүгээр хавсралт

ТТБ8279 № 9087524

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМИЙГ АЖИЛЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн тогтолцоог боловсронгуй болгох, хэрглэгчийг найдвартай, шуурхай, үнэн зөв мэдээллээр хангах, мэдээллийн санг эрхлэн хөтлөх дээрх чиглэлээр мэдээлэл оруулагч байгууллагын мэдээлэл солилцооны болон үйл ажиллагааны уялдаа холбоог хангахтай холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем /цаашид “ЭЗМНС” гэх/-ийг эрхлэн хөтлөхдөө хууль дээдлэх, хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад бүх мэдээлэл нээлттэй байх, үйл ажиллагааны хувьд шуурхай, ил тод байх зарчмыг баримтална.

1.3. ЭЗМНС-ийн мэдээллийн сан /цаашид “Мэдээллийн сан” гэх/ нь олон нийтэд нээлттэй, үнэ төлбөргүй байна.

1.4. ЭЗМНС нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 45.3-т заасны дагуу эрх зүйн мэдээллийн албан ёсны /www.legalinfo.mn/ нь цахим хуудастай байна.

1.5. ЭЗМНС-ийн сервер, сүлжээний тоног төхөөрөмж, програм хангамж, мэдээллийн сан нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд эзэмшүүлсэн төрийн өөрийн өмч байна.

Хоёр. Журмын нэр томъёо

2.1. Энэ журамд заасан дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.1.1. “ЭЗМНС” гэж техник болон программ хангамж, мэдээллийн сан, санхүү, хүний нөөц-зохион байгуулалтын нэгдсэн тогтолцоог;

2.1.2. “Мэдээллийн сан” гэж ЭЗМНС-д төвлөрсөн энэ журмын 3.2-т заасан мэдээ, мэдээллийн нэгдсэн санг;

2.1.3. “Эрх бүхий этгээд” гэж системийн зохицуулагч, хянагч, мэдээлэл оруулагч, портал зохицуулагчийг;

2.1.4.“Системийн зохицуулагч” гэж ЭЗМНС-ийн өдөр тутмын ажлыг хариуцан ажиллаж бусад холбогдох эрх бүхий /хянагч, мэдээлэл оруулагч, портал зохицуулагч/ этгээдэд системд хандах тусгай эрх олгохтой холбоотой асуудлыг хариуцаж, ЭЗМНС-ийн аюулгүй байдлыг хангах этгээдийг;

2.1.5.“Хянагч” гэж системийн зохицуулагчаас олгосон тусгай эрхийн дагуу ЭЗМНС-д мэдээлэл оруулагчаас оруулсан мэдээллийг хянах эсхүл мэдээлэл оруулагчид илэрсэн алдааны талаар буцаан мэдээлэх эрх бүхий ажилтныг;

2.1.6.“Мэдээлэл оруулагч” гэж системийн зохицуулагчаас олгосон тусгай эрхийн дагуу ЭЗМНС-д энэ журмын 3.2-т заасан мэдээ, мэдээллийг системд оруулж, актын өөрчлөлт хөдөлгөөнийг хийж байх үүрэг бүхий холбогдох байгууллагын ажилтныг;

2.1.7.“Портал зохицуулагч” гэж системийн зохицуулагчаас олгосон эрхийн дагуу системд нэвтэрч цахим хуудасны хэлбэр, бүтцэд өөрчлөлт хийх, мэдлэгийн сан, асуулт хариулт зэрэг буланг хөтлөх эрх бүхий этгээдийг;

2.1.8.“Дэд систем” гэж физик холболтоор шууд холбогдсон Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс өөр газар байрлах, системийн зохицуулагчаас олгосон эрхийн дагуу зохих мэдээлэл оруулах эрх бүхий мэдээлэл оруулагч, хянагчийн байгууллага;

2.1.9.“Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалт” гэдгийг Монгол Улсын Их Хурал 2014 оны 12 дугаар сарын 5-ны өдөр соёрхон баталсан “Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалтын асуудлаар ил тод байдлыг хангах тухай” Монгол Улс, Америкийн Нэгдсэн Улс хоорондын хэлэлцээр болон Монгол Улсаас бусад улстай байгуулсан худалдаа болон хөрөнгө оруулалтыг хөхиулэн дэмжих, харилцан хамгаалах тухай хэлэлцээрт заасан утгаар ойлгоно;

2.1.10.“Захиргааны байгууллага” гэдгийг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

Гурав. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн бүтэц

3.1.Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем нь дараахь бүрэлдэхүүн хэсгүүдтэй байна.

3.1.1.Програм хангамж;

3.1.2.Техник хангамж;

3.1.3. Мэдээллийн сан;

3.1.4. Хүний нөөц-зохион байгуулалт;

3.1.5. Санхүүгийн нөөц.

3.2.Мэдээллийн сан нь дараахь бүрэлдэхүүн хэсэгтэй байна.

3.2.1.Монгол Улсын хууль;

- 3.2.2. Монгол Улсын Олон Улсын гэрээ;
- 3.2.3. Монгол Улсын Их Хурлын тогтоол;
- 3.2.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, захирамж;
- 3.2.5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэр;
- 3.2.6. Монгол Улсын дээд шүүхийн шийдвэр;
- 3.2.7. Монгол Улсын Засгийн газрын тогтоол;
- 3.2.8. Монгол Улсын Сайдын тушаал;
- 3.2.9. Засгийн газрын агентлагийн даргын тушаал;
- 3.2.10. Улсын Их Хурлаас томилогддог байгууллагын даргын шийдвэр;
- 3.2.11. Аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэр;
- 3.2.12. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас гаргасан шийдвэр;
- 3.2.13. Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж;
- 3.2.14. Сум, дүүргийн Засаг даргын захирамж;
- 3.2.15. Захиргааны бусад байгууллагаас баталсан захиргааны хэм хэмжээний акт;
- 3.2.16. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл, англи хэлээрх тайлбар;

3.2.17. Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөл, хууль зүйн ач холбогдол бүхий бусад мэдээ, мэдээлэл.

3.3. [legalinfo.mn](http://www.legalinfo.mn/) цахим хуудас дээр эрх зүйн чиглэлийн сурталчилгаа байрлуулах, захиргааны хэм хэмжээний актыг гаргаж байгаа байгууллага нь захиргааны хэм хэмжээний актын төслөө уг нэгдсэн санг ашиглан олон нийтээр хэлэлцүүлж, санал авах үйл ажиллагааг төлбөртэйгээр зохион байгуулж болно.

3.4. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд цахим хуудасны <http://www.legalinfo.mn/> домайн хаягаар нэвтэрнэ.

3.5. Эрх зүйн мэдээллийн сангийн хайлтын програм хангамж нь эрх зүйн мэдээллийг эрх зүйн актын ангиллаар, статистик /огноо, дугаар, гарчиг, хүчин төгөлдөр үйлчилж байгаа эсэх гэх мэт/ болон динамик /үгээр, агуулгын мэдрэмжтэйгээр/ хайлт хийх, хайлтын үр дүнг нэгтгэн харуулах боломжтой байна.

Дөрөв. Мэдээллийн санг бүрдүүлэх, эрхлэн хөтлөх

4.1. Энэ журмын 3.2.7-3.2.15-т заасан шийдвэр нь захиргааны хэм хэмжээ тогтоосон нийтээр дагаж мөрдөх шийдвэр байна.

4.2. Захиргааны хэм хэмжээний актыг баталсан эрх бүхий этгээд нь уг актын баталгаажсан хуулбарыг цахим хувилбарын хамт Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлнэ.

4.3. Хууль зүй, дотоод хэргийн яам нь энэ журмын 3.2.7-3.2.15-т заасан захиргааны хэм хэмжээний актыг эх хувь болон цахим хувилбарын хамт Хууль зүйн үндэсний хүрээлэнд хүргүүлнэ.

4.4. Цахим мэдээллийн бичвэрт “Баримт бичгийн бүрдлүүд, тэдгээрт тавих шаардлага” MNS 5141:2002, “Баримт бичгийн хэвлэмэл хуудас, тэдгээрт бүрдлүүдийг байрлуулахад тавигдах шаардлага” MNS 5142:2002 Монгол Улсын стандартыг хэрэглэнэ.

4.5. ЭЗМНС-д оруулсан эрх зүйн актад өөрчлөлт хөдөлгөөнийг тусгахдаа Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2009 оны 3 дугаар сарын 11-ний өдөр баталсан “Эрх зүйн актыг бүртгэх, эрх зүйн актын ангилагчийг ашиглаж системчилсэн картын сан, хяналтын хувийг хөтлөх аргачилсан зөвлөмж”-ийг баримтална.

4.6. Энэ журмын 3.2-д заасан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг оруулахдаа мэдээлэл оруулагч нь энэ тушаалын 2 дугаар хавсралтад заасан хугацааг баримтална.

4.7. Хууль зүйн үндэсний хүрээлэн нь ЭЗМНС-д орсон хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актыг эрх зүйн ангилагчийн дагуу ангилах, өөрчлөлт хөдөлгөөнийг хийх, хянагдсан мэдээллийг эцсийн хэрэглэгчид түгээх ажлыг хариуцна.

4.8. ЭЗМНС-д мэдээлэл оруулах эрх бүхий байгууллага нь мэдээлэл оруулах ажилтны ажлын байрны тодорхойлолтод мэдээлэл оруулагчийн чиг үүргийг тусгайлан тусгаж өгнө.

4.9. ЭЗМНС-д мэдээлэл оруулагч нь оруулсан мэдээллийн талаарх тайлангаа системийн зохицуулагчид тухай бүр ирүүлж байна.

4.10. ЭЗМНС-д оруулсан хууль тогтоомж, эрх зүйн актын хувьд маргаан, эргэлзээ гарвал тухайн хууль тогтоомж, эрх зүйн актын албан ёсны эх “Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д нийтлэгдсэн хувь, захиргааны хэм хэмжээний актын хувьд улсын бүртгэлд бүртгүүлсэн эх хувь болон “Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”-д нийтлэгдсэн хувийг баримтална.

Тав. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, гэрээ, тэдгээрийн төсөл, төслийн англи хэлээрх бичвэрийг ЭЗМНС-д оруулах, эрхлэн хөтлөх

5.1. Монгол Улсаас бусад улстай байгуулсан олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой олон улсын гэрээ болон түүний англи хэлээрх бичвэрийг гадаад

харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага ЭЗМНС-д байршуулах ажлыг гүйцэтгэнэ.

5.2. Энэ журмын 5.1-д заасан олон улсын гэрээний англи хэлээрх бичвэр нь тайлбар хэлбэртэй байж болно.

5.3. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхээс 60-аас доошгүй хоногийн өмнө тухайн төсөл болон түүний англи хэлээрх тайлбарыг олон нийтэд танилцуулж, санал авахаар хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага ЭЗМНС-д байршуулна.

5.4. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой захиргааны хэм хэмжээний актыг батлагдахаас 60-аас доошгүй хоногийн өмнө тухайн төсөл болон түүний англи хэлээрх тайлбарыг олон нийтэд танилцуулж санал авахаар тухайн актыг батлах захиргааны байгууллага ЭЗМНС-д байршуулна.

5.5. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний актын төсөлд олон нийт саналаа монгол, эсхүл англи хэлээр өгч болно.

5.6. Олон нийтээс ирүүлсэн саналыг үндэслэн төсөлд оруулсан томоохон өөрчлөлтийн талаарх мэдээлэл, тэдгээрийн англи хэлээрх тайлбарыг 5.3, 5.4-д заасан байгууллагууд ЭЗМНС-д байршуулна.

5.7. Энэ журмын 5.6-д заасан захиргааны хэм хэмжээний актыг баталсан байгууллага нь уг актын эх хувийг, англи хэлээрх албан ёсны орчуулгын хамт хууль зүй, дотоод хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

5.8. Олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой хууль тогтоомжийг батлагдсанаас хойш 90 хоногийн дотор хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага англи хэлээр орчуулж ЭЗМНС-д байршуулна.

5.9. Энэ журмын 5 дахь хэсэгт заасан хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, тэдгээрийн төслийг олон нийтэд хүргэх, англи хэлээр орчуулах ажлын төсвийг тухайн байгууллага төсөвтөө суулгах замаар шийдвэрлэнэ.

Зургаа. ЭЗМНС-ийн хөгжүүлэлт, техник хангамж, аюулгүй ажиллагаа

6.1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн сервер, програм хангамж, мэдээллийн сан нь “Үндэсний дата төв”-д, системийн нөөц хуулбар нь Хууль зүйн үндэсний хүрээлэнд байрлана.

6.2. ЭЗМНС-ийн сервер, техник хангамжийн аюулгүй байдал, хэвийн ажиллагаа, системийн хөгжүүлэлт, програм хангамжийг сайжруулах, боловсронгуй болгох ажлыг

Хууль зүйн үндэсний хүрээлэн хариуцах бөгөөд энэ ажлыг хэрэгжүүлэхдээ мэргэжлийн байгууллага, мэргэжилтэнтэй хамtran ажиллах, туслалцаа авах байдлаар хэрэгжүүлж болно.

6.3. Системийн зохицуулагч нь системийн өдөр тутмын үйл ажиллагаа, түүний аюулгүй байдал болон мэдээллийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж хянач, мэдээлэл оруулагч, ангилагч, портал зохицуулагчид системд хандах тусгай эрхийг олгоходоо энэхүү тушаалын 2 дугаар хавсралтад заасан мэдээлэл оруулагч байгууллагын хариуцах газар /хэлтэс/-ын даргын бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэнэ.

6.4. ЭЗМНС, дэд системийн сүлжээнд нэвтрэх эрхийг системийн зохицуулагч олгоно.

6.5. Энэ журмын 6.3-т заасан ажилтан бүр мэдээллийн системд зөвхөн өөрийн гэсэн нэвтрэх нэртэй байна.

6.6. Системд нэвтрэх нэр нь тодорхой тооны үсэг, тоогоор илэрхийлэгдсэн байх бөгөөд ажилтны нэр, албан тушаалыг төлөөлсөн байна.

6.7. Амжилтгүй нэвтрэх оролдлогын үед нэвтрэх оролдлогын давталтын хоорондын зайд 3 секундээс дээш болон давталтын тоо 3-аас илүүгүй байна. Олон дахин амжилтгүй нэвтэрсэн үед нэвтрэх нэр хаагддаг байхаар тохируулна.

6.8. Системд нэвтрэх амжилтгүй оролдлого бүрт системийн зохицуулагчид мэдэгдэж байхаар тохируулна.

6.9. ЭЗМНС-д амжилтгүй нэвтрэх оролдлогын үед нэвтрэх нэр, нууц үгийн аль нь алдаатай болох нь харагдахгүй байхаар тохируулна.

6.10. Нэвтрэх нэр, нууц үгээр аливаа системд давтан холболтыг хийхгүй.

6.11. Мэдээлэл оруулагч байгууллагын ажилтан хөдөлмөрийн гэрээгээ цуцлах, ажлаас чөлөөлөгдөх болон хөдөлмөрийн хуульд заасан бусад нөхцөл байдал бий болсон тухай байгууллагын эрх бүхий албан тушаалтан мэдэгдсэн даруйд системийн зохицуулагч нь системд нэвтрэх нэрийг хааж хүчингүй болгоно.

6.12. Дэлгэцийг цоожлох системийг 5 минутаас бага хугацаанд идэвхждэг байлгана.

6.13. Энэ журмын 6.3-т заасан ажилтан нь цахим шууданг шалгахдаа илгээгчийг заавал нягтална.

6.14. Энэ журмын 6.3-т заасан ажилтан нь цахим шуудангаар ирсэн бүх төрлийн өргөтгөлтэй хавсралт файлыг нээж үзэхдээ холбогдох шинэчлэл хийгдсэн антивирусийн програмаар заавал шалгана.

6.15. Дэд системийн сүлжээний тоног төхөөрөмжийн нөөц боломжийг ЭЗМНС-ийн болон бусад зорилгоор ашиглах тохиолдолд системийн зохицуулагч заавал мэдэгдэж зөвшөөрөл авна.

6.16. ЭЗМНС-д нэвтрэх эрх бүхий ажилтан нь дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

- 6.16.1. Аливаа системд нэвтрэх нэр, нууц үгийг бусдад дамжуулах;
- 6.16.2. ЭЗМНС-д нууц үг шалгагч системийг ажиллуулах;
- 6.16.3. Алсын удирдлагын системүүд ажиллуулах;
- 6.16.4. ЭЗМНС-д ашигладаг аливаа компьютерийн системд нэвтрэх нууц үгийг алдагдуулах;
- 6.16.5. Сүлжээний протокол задлагч програмыг ажиллуулах;
- 6.16.6. Системд өөр эрх ашиглан нэвтрэх;
- 6.16.7. Оюуны өмчийн зөвшөөрөлгүй програм буюу програмын хуулбарыг ашиглах.

Долоо. Санхүүжилт

7.1. ЭЗМНС-ийн хөгжүүлэлт, програм хангамжийн сайжруулалт, сервер, техник тоног төхөөрөмжийн шинэчлэлт, засвар үйлчилгээнд шаардагдах төсөв хөрөнгийг Хууль зүй, дотоод хэргийн яам жил бүр өөрийн төсөвтөө тусгайлан тусгуулах ажлыг хариуцна.

Найм. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага

- 8.1. Энэхүү журмын хэрэгжилтэд баталсан байгууллага бүр хяналт тавьж ажиллана.
- 8.2. Энэ журамд заасан байгууллага ЭЗМНС-д оруулсан мэдээллийн техникийн болон агуулгын үнэн зөв, алдаагүй байдлыг бүрэн хариуцна.
- 8.3. Мэдээллийн санд мэдээлэл нийлүүлэх хугацаа хожимдуулсан, үнэн зөв биш мэдээлэл оруулсан, эсвэл оруулах ёстай мэдээллийг оруулаагүй бол тухайн байгууллагын удирдлага буруутай ажилтанд байгууллагынхаа хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.
- 8.4. Хууль зүйн үндэсний хүрээлэн нь энэ журамд дурдсан байгууллагын оруулсан хууль тогтоомж болон эрх зүйн бусад актыг бүрэн оруулсан эсэхэд хяналт тавих ерөнхий хянаагчийн эрхтэй байх бөгөөд энэ журмын 4.8-д заасны дагуу ажиллана.
- 8.5. Тушаал захирамжийн 2 дугаар хавсралтад заасан байгууллагууд ЭЗМНС-д оруулсан мэдээллийн тайланг хагас жилд 1 удаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд ирүүлж байна.
- 8.6. Цахим хуудасны үйл ажиллагааны өнөөгийн байдал, хэтийн төлөв байдал, эрх зүйн мэдээллийг олон нийтэд хүргэх ажлыг боловсронгуй болгох болон холбогдох бусад асуудлын талаар мэдээлэл оруулах, хяналт тавих үүрэг бүхий байгууллагууд хамтран санал солилцох ажлын уулзалтыг хагас жилд 1 удаа зохион байгуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Гадаад харилцааны сайд Монгол Улсын Их Хурдын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга, Монгол Улсын Ерөнхий лэгчийн Тамгын гасрын дарга Монгол Улсын Үндсэн хуулийн нэцийн Тамгын газрын дарга Монгол Улсын Дээд шүүхийн Тамгын газрын дарга нарын хамтарсан 2011 оны 17.11.2011 дугаар тушаал, захирамжийн 2 дугаар хавсралт

**ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН ТЭГДСЭН САНД БАЙРШУУЛАХ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ,
ХУГАЦАА, ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА**

ХАГАЦАА, ХАРИУЦАЛ ВАН УЗҮҮЛАГА			
Д/д	Байгууллагын нэр	Оруулах мэдээллийн төрөл	Оруулах хугацаа
1.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар	Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг захирамж	Хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 өдрийн дотор
2.	Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар	Үндсэн хуулийн Цэцийн а/ дүгнэлт б/ тогтоол	Дүгнэлт, тогтоолыг есчилсноос хойш ажлын 5 өдрийн дотор
3.	Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газар	Улсын дээд шүүхийн хууль тайлбарласан тогтоол	Ёсчлögдсноос хойш ажлын 5 өдрийн дотор
4.	УИХ-ын Тамгын газар	а/ Монгол Улсын хууль б/ УИХ-ын тогтоол	“Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д нийтлэгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор
5.	Гадаад харилцааны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага	Монгол Улсын олон улсын гэрээ, түүний англи хэлээрхи бичвэр	“Хууль тогтоомжийн эмхэтгэл”-д нийтлэгдсэнээс хойш ажлын 5 өдрийн дотор
6.	Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	Засгийн газрын тогтоол	Хүчин төгөлдөр болсноос хойш ажлын 5 өдрийн дотор
7.	Хууль зүй, дотоод хэргийн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн	<ul style="list-style-type: none"> ➤ Захиргааны хэм хэмжээний акт, /олон улсын худалдаа, хөрөнгө оруулалттай холбоотой захиргааны хэм хэмжээний актыг англи хэлээрхи бичвэрийн хамт/ ➤ Хууль зүйн нэр томъёоны мэдээллийн хэсэг ➤ Хууль зүйн ач холбогдол бүхий мэдээ, мэдээлэл 	Тухай бүр